

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 3 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2026/63/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Дархан-Уул аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр:

Утас: 70378845

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер: У.Батсүрэн

Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг

Утас: 70373089

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Хаан консалтинг аудит ХХК

Гүйцэтгэх захирал: Э.Нандинчимэг

Утас: 88883776

Цахим хаяг: khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
5.1 Төлбөрийн акт	9
5.2 Албан шаардлага.....	9
5.3 Зөвлөмж	10
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	11

Товчилсон үгийн жагсаалт

ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Бурхантын гудамж-1,14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 65

танай _____-ны № _____-т

ДАРХАН СУМЫН 3 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
М.СОЁЛМАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 3 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 3 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Боловсролын газраас бүх цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд зориулан хэрэгцээт багаж хэрэгсэл болон тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд тус байгууллага нь хүүхдийн хоол хүнсний бүтээгдэхүүн худалдан авах төлөвлөгөөнд тусгагдаагүй бүтээгдэхүүн худалдан авч хоол үйлдвэрлэлд зарцуулсан, худалдан авалтын гэрээг байгуулахдаа нэгж үнэ, тоо ширхэг, бүтээгдэхүүний нэр төрлийг хавсаргаж баталгаажуулаагүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна.

4528050174

Бусад асуудал

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн хүрээнд авсан судалгаанд дүн шинжилгээ хийж, эрсдэл бүхий асуудалд анхаарал хандуулсан болно.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 3 дугаар цэцэрлэг нь 2025 онд 4 зорилт 65 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 97.8 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	297,904,082.93	127,115,545.74
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	228,792,831.93	26,463,269.24
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	228,792,831.93	26,463,269.24
31211	Төрийн сангийн харилцах	228,792,831.93	26,463,269.24
35	БАРАА МАТЕРИАЛ	69,111,251.00	100,652,276.50
351	Түүхий эд материал	2,298,320.00	2,021,820.00
35130	Эм боох материал	2,298,320.00	2,021,820.00
354	Хангамжийн материал	66,812,931.00	98,630,456.50
35410	Бичиг хэргийн материал	1,126,000.00	1,176,000.00
35420	Аж ахуйн материал	33,471,560.00	-
35450	Барилгын засварын материал	165,000.00	165,000.00
35460	Хүнсний материал	14,496,127.00	10,019,078.50
35470	Бусад хангамжийн материал	17,554,244.00	87,270,378.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,460,536,583.86	1,448,349,730.72
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,460,536,583.86	1,448,349,730.72
392	Биет хөрөнгө	1,330,143,583.84	1,318,110,730.66
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,364,847,123.00	1,364,847,123.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(159,864,742.51)	(189,214,771.03)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	125,506,200.00	147,611,100.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(24,338,203.37)	(36,405,457.58)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	55,046,922.07	44,713,676.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	(37,463,193.01)	(18,239,371.15)
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,155,300.00	8,155,300.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2,841,602.34)	(3,356,869.38)
39217	Ном	1,095,780.00	-
393	Биет бус хөрөнгө	130,393,000.02	130,239,000.06
39301	Програм хангамж	770,000.00	770,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(76,999.98)	(230,999.94)
39303	Бусад биет бус хөрөнгө	129,700,000.00	129,700,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,758,440,666.79	1,575,465,276.46
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,758,450,666.79	1,575,475,276.46
51	Засгийн газрын хувь оролцоо	1,758,450,666.79	1,575,475,276.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	469,207,470.20	469,207,470.20
511001	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	469,207,470.20	469,207,470.20
512	Хуримтлагдсан үр дүн	913,501,163.48	730,855,773.15
51210	Өмнөх үеийн үр дүн	913,501,163.48	913,831,163.48
51220	Тайлант үеийн үр дүн	-	(182,975,390.33)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	375,742,033.11	375,412,033.11
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,758,450,666.79	1,575,475,276.46

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,167,685,600.00	995,008,390.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	96,540,000.00	102,927,690.00
120	Нийтлэг татварын бус орлого	96,540,000.00	102,927,690.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,285,700.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	12,846,500.00	3,584,700.00

120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	80,047,500.00	44,313,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	3,646,000.00	50,744,290.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,071,145,600.00	892,080,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,021,445,600.00	832,443,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,021,445,600.00	832,443,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	49,700,000.00	59,636,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49,700,000.00	59,636,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	987,120,788.12	1,173,978,005.57
21	УРСГАЛ ЗАРДАЛ	987,120,788.12	1,173,978,005.57
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	975,524,376.42	1,165,734,977.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	658,425,303.35	788,168,157.69
210101	Үндсэн цалин	477,693,211.35	532,774,304.21
210102	Нэмэгдэл	167,343,292.00	202,769,867.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	28,695,116.87
210104	Урамшуулал	13,388,800.00	23,928,869.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,612,066.13	98,335,400.00
210201	Тэтгэврийн даатгал	57,077,799.13	66,723,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,720,554.00	7,903,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,350,324.00	3,951,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,301,419.00	3,951,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,161,970.00	15,806,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,378,888.30	49,636,772.06
210301	Гэрэл, цахилгаан	11,423,911.79	22,132,706.22
210302	Түлш, халаалт	11,767,831.46	11,049,161.78
210303	Цэвэр, бохир ус	13,187,145.05	16,454,904.06
2105	Нормативт зардал	102,440,328.00	104,410,123.50
210502	Хоол, хүнс	102,440,328.00	104,410,123.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,500,000.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	12,500,000.00	10,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,046,682.00	2,935,630.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,046,682.00	2,935,630.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	80,121,108.64	112,248,894.38
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,710,806.00	45,541,516.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,185,300.00	7,353,600.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	49,225,002.64	59,353,778.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,596,411.70	8,243,027.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,775,300.00	8,243,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,775,300.00	8,243,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	821,111.70	27.94
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	821,111.70	27.94
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	180,564,811.88	(178,969,615.57)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	284,700.00	4,005,774.76
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	284,700.00	4,005,774.76
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(284,700.00)	(4,005,774.76)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	180,280,111.88	(182,975,390.33)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,071,145,600.00	896,366,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	4,285,700.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	4,285,700.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	4,285,700.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	4,285,700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,071,145,600.00	892,080,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,021,445,600.00	832,443,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,021,445,600.00	832,443,900.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	49,700,000.00	59,636,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	49,700,000.00	59,636,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	946,833,121.48	1,095,420,962.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	946,833,121.48	1,095,420,962.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	935,236,709.78	1,087,177,934.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	658,425,303.35	788,168,157.69
210101	Үндсэн цалин	477,693,211.35	532,774,304.21
210102	Нэмэгдэл	167,343,292.00	202,769,867.61
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	28,695,116.87
210104	Урамшуулал	13,388,800.00	23,928,869.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	83,612,066.13	98,335,400.00
210201	Тэтгэврийн даатгал	57,077,799.13	66,723,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	6,720,554.00	7,903,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,350,324.00	3,951,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,301,419.00	3,951,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	13,161,970.00	15,806,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,378,888.30	49,636,772.06
210301	Гэрэл, цахилгаан	11,423,911.79	22,132,706.22
210302	Түлш, халаалт	11,767,831.46	11,049,161.78
210303	Цэвэр, бохир ус	13,187,145.05	16,454,904.06
2105	Нормативт зардал	110,206,270.00	99,933,075.00
210502	Хоол, хүнс	110,206,270.00	99,933,075.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,500,000.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	12,500,000.00	10,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,046,682.00	2,935,630.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,046,682.00	2,935,630.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,067,500.00	38,168,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,292,200.00	28,373,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,775,300.00	9,795,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,596,411.70	8,243,027.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,775,300.00	8,243,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,775,300.00	8,243,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	821,111.70	27.94
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	821,111.70	27.94
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	124,312,478.52	(199,054,562.69)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	5,352,100.00	3,275,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,352,100.00	3,275,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	5,352,100.00	3,275,000.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,352,100.00	3,275,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(5,352,100.00)</u>	<u>(3,275,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	118,960,378.52	(202,329,562.69)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	109,832,453.41	228,792,831.93
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	228,792,831.93	26,463,269.24

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	469,207,470.20	375,742,033.11	733,221,051.60	1,578,170,554.91
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	469,207,470.20	375,742,033.11	733,221,051.60	1,578,170,554.91
Тайлант үеийн үр дүн	-	-	180,280,111.88	180,280,111.88
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	469,207,470.20	375,742,033.11	913,501,163.48	1,758,450,666.79
2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	469,207,470.20	375,742,033.11	913,501,163.48	1,758,450,666.79
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	330,000.00	330,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	469,207,470.20	375,742,033.11	913,831,163.48	1,758,780,666.79
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	(330,000.00)	-	(330,000.00)
Тайлант үеийн үр дүн	-	-	(182,975,390.33)	(182,975,390.33)
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	469,207,470.20	375,412,033.11	730,855,773.15	1,575,475,276.46

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	228,792,831.93	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,060,013,700.00	1,039,059,162.69	20,954,537.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,060,013,700.00	1,039,059,162.69	20,954,537.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,051,770,700.00	1,030,816,162.69	20,954,537.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	791,710,800.00	788,168,157.69	3,542,642.31
210101	Үндсэн цалин	532,364,700.00	532,774,304.21	-409,604.21
210102	Нэмэгдэл	239,275,200.00	202,769,867.61	36,505,332.39

210103	Унаа хоолны хөнгөлөлт		28,695,116.87	-
210104	Урамшуулал	20,070,900.00	23,928,869.00	-3,857,969.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,335,400.00	98,335,400.00	0.00
210201	Тэтгэврийн даатгал	66,723,300.00	66,723,300.00	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,903,000.00	7,903,000.00	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,951,500.00	3,951,500.00	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,951,500.00	3,951,500.00	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,806,100.00	15,806,100.00	0.00
2105	Нормативд зардал	114,648,200.00	99,933,075.00	14,715,125.00
210502	Хоол хүнс	114,648,200.00	99,933,075.00	14,715,125.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,301,900.00	2,935,630.00	2,366,270.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээ	5,301,900.00	2,935,630.00	2,366,270.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,774,400.00	41,443,900.00	330,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	31,979,400.00	31,648,900.00	330,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,795,000.00	9,795,000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,243,000.00	8,243,000.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,243,000.00	8,243,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,243,000.00	8,243,000.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,060,013,700.00	836,729,600.00	223,284,100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	840,755,600.00	832,443,900.00	8,311,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	840,755,600.00	832,443,900.00	8,311,700.00
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	219,258,100.00	4,285,700.00	214,972,400.00
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,285,700.00	4,285,700.00	0.00
	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	214,972,400.00		214,972,400.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	228,792,831.93	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	26,463,269.24	

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	84,001,800.00	59,636,772.06	24,365,027.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	84,001,800.00	59,636,772.06	24,365,027.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	84,001,800.00	59,636,772.06	24,365,027.94
2103	БАЙР АШИГЛАЛТТАЙ ХОЛБООТОЙ ТОГТМОЛ ЗАРДАЛ	74,001,800.00	49,636,772.06	24,365,027.94
210301	Гэрэл, цахилгаан	28,087,000.00	22,132,706.22	5,954,293.78
21302	Түлш халаалт	25,942,000.00	11,049,161.78	14,892,838.22
21303	Цэвэр, бохир ус	19,972,800.00	16,454,904.06	3,517,895.94
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	10,000,000.00	0.00

210604	Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00	0.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	84,001,800.00	59,636,772.06	24,365,027.94
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	84,001,800.00	59,636,772.06	24,365,027.94
132001	Орон нутгийн төсвөөс	84,001,800.00	59,636,772.06	24,365,027.94

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3,694.4 мянган төгрөгийн зөрчил¹ илэрсэн тул 2 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ. Үүнд:

5.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд тус цэцэрлэгийн бараа үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгч М.Соёлмаагийн сургалтын төлбөрт 600,000.00 төгрөг төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 39 дүгээр тогтоолоор баталсан “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”-ын хавсралт “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлын хэмжээний бүрэлдэхүүн, зардлын зориулалт, эдийн засгийн ангиллын дэлгэрэнгүй заавар”-ын 3-д “Багшийн хөгжил буюу мэргэжил дээшлүүлэх зардалд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны хөгжих хэрэгцээнд суурилсан цахим платформд түшиглэн явуулах тусгай сургалт (1, 5, 10 жилийн сургалтаас бусад), бусад сургалт үйл ажиллагааны зардал багтана” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

2. Тус цэцэрлэгийн эрхлэгч М.Соёлмаад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл хөлсийг гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирох цалин хөлснөөс тооцоогүйгээс нийт 475.2 мянган төгрөг илүү олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах” 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1-д “Ажил олгогч нь ажилтантай тохиролцсоноор ажил хослон гүйцэтгүүлэх, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх, ажилтны ажлын цагт багтаан өөр ажил, албан тушаал хавсран гүйцэтгүүлэх, ажлын ачааллыг нэмэгдүүлэх хэлбэрээр ажиллуулж болно”, 56.2-т “Энэ хуулийн 56.1-д заасны дагуу ажиллах ажилтанд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.2 Албан шаардлага

1. Тайлант онд тус цэцэрлэгийн эрхлэгч М.Соёлмаа нь Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалыг үндэслэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл цалин хөлсөнд нийт 2,619,200.00 төгрөг авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хяналт тавих үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын захирал /эзэн/, ажил олгогч шууд хариуцна”, 27.6-д “Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтцийн

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

жишиг, ажилтны орон тооны норматив, зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална", Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын 1.В хэсэгт "Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг аль нэг ажилтанд хавсран хариуцуулна. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1 Хоол хүнс зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хүүхдийн хоолны зарцуулалтыг тулгахад хүнсний ул мөрийн дэвтрийг 11.27-оос хойш хөтлөөгүй, тогоочийн захиалгын хуудас дахь материалын жагсаалт хоолны цэстэй тохирохгүй, хоолны цэс нь технологи карт хоолны цэстэй тохирохгүй, хоолны үндсэн түүхий эд махыг хүүхдийн ирц, технологи картын орц нормоос дутуу олгосон зэрэг нь хоолны материалын зарцуулалт үнэн зөв эсэхэд эргэлзээтэй.нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-т "Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-т "Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 дэх заалтыг баримталж, анхан шатны баримтыг бүрдүүлж ажиллах.

Дээрх тайлангийн 3.5.5 дахь хэсэгт дурдсан Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилд өгсөн албан шаардлага, 4.4.1 дэх хэсэгт дурдсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчилд өгсөн хариуцлага тооцох албан шаардлага, 5.1 дэх хэсэгт дурдсан төлбөрийн акт, 5.2 дахь хэсэгт дурдсан албан шаардлага, 5.3 дахь хэсэгт дурдсан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5²-д заасны дагуу ирүүлэх, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Тайл бар
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	
Тайлант онд тус цэцэрлэгийн бараа, үйлчилгээний бусад зардлаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтад хамрагдсан эрхлэгчид сургалтын төлбөр төлж, батлагдсан төсвийг үр ашиггүй зарцуулсан.	1	600.0	1	600.0	-	-	-	-	-	-	
Эрхлэгчид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл хөлсийг гүйцэтгэсэн ажил үүрэгт нь тохирох цалин хөлснөөс тооцоогүйгээс нийт 475.2 мянган төгрөг илүү олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан	1	475.2	1	475.2							
Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцан ажилласны нэмэгдэл	1	2,619.2	-	-	1	2,619.2	-	-	-	-	

цалин хөлс авч, хууль тогтоомжийн хүрээнд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлээгүй											
Хүүхдийн хоолны зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэл дутуу байна	1	-			-	-	1	-			
Дүн	4	3,694.4	1	1,072.5	1	2,619.2	1	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Хүүхдийн хоол хүнсний худалдан авалтын гэрээнд нэгж үнийг хавсаргаж баталгаажуулаагүй, тайлант хугацааны эцэст гэрээ дүгнэж акт үйлдээгүй	1	99,933.1			1	99,933.1		
Хүүхдийн хоол хүнсний худалдан авалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 7,509.8 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн худалдан авч хоол үйлдвэрлэлд зарцуулсан	1	7,509.8			1	7,509.8		
Дүн	2	107,137.3	-	-	2	107,137.3	-	-